



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/320

Улаанбаатар хот

Өрхийн эрүүл мэндийн төвийн
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4,5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Дүрмийг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Гэрэлмаа)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/212 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141241281

Эрүүл мэндийн сайдын 2024 оны ...
дугаар сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Өрхийн эрүүл мэндийн төв нь (цаашид “төв” гэх) Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2-т зааснаар хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.
- 1.2. Төв нь Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нөхөрлөлийн тухай, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох тогтоол, тушаал шийдвэр, стандарт, энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.
- 1.3. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна. Нөхөрлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээс бусад хэлбэрээр байгуулагдана.
- 1.4. Төв нь улсын бүртгэлд бүртгүүлэн, эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан байна.
- 1.5. Төв нь оноосон нэртэй байх бөгөөд албан ёсоор баталгаажсан тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.6. Төв нь “Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг баримтлан, Эрүүл мэндийн газартай жил бүр гэрээ байгуулж ажиллана. Гэрээг Аймаг, нийслэлийн засаг дарга нар батламжилна. Нийслэлийн Засаг дарга нь Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу гэрээ байгуулах эрхийг дүүргийн удирдлагад шилжүүлж болно.
- 1.7. Төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн нэг иргэнд тооцсон санхүүжилтээр санхүүжнэ.
- 1.8. Төв нь улс төрөөс ангид байж зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаа явуулна.
- 1.9. Өрхийн эрүүл мэндийн төвийн ногдох иргэний доод хязгаар нь аймаг орон нутагт 8000-аас доошгүй, нийслэлд 10000-аас доошгүй байна.

1.10. Төвийг аймагт Эрүүл мэндийн газар, нийслэлд Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв нь мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.11. Өрхийн эрүүл мэндийн төв нь өөрийн харьяа хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд салбартай байж болно.

1.12. Төвийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зориулалтын эмнэлгийн байр, багаж тоног төхөөрөмж, машинаар хангахад дэмжлэг үзүүлэх талаар Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн гэрээнд тусгаж, Аймаг, нийслэлийн Засаг дарга баталж хэрэгжүүлнэ.

1.13. Төв нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

Хоёр. Төвийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна.

2.2. Хурлын шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд гишүүдийн олонх дэмжиж гаргасан, бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулж, шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хүлээнэ.

2.3. Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас тус төвийн удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүнийг томилж, чөлөөлнө.

2.4. Нөхөрлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг хамт олонд танилцуулж, протокол хөтөлсөн байна.

2.5. Төвийн дарга нь 1800-2200 иргэнд 1 өрхийн эмч, 1 өрхийн сувилагч ноогдохоор тооцон, дархлаажуулалт, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээ, статистик дүн бүртгэл болон бусад ажилтныг сонгож ажиллуулна.

2.6. Төвийн удирдлага нь ил тод нээлттэй, шударга, хамт олныг манлайлах, багаар ажиллахыг үйл ажиллагааны үндсэн зарчмаа болгож, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл

3.1. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас “Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт”-д заасан тусламж, үйлчилгээг харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлнэ.

3.2. Хүн амын эрүүл мэндийг 5 бүлгээр тодорхойлон, эрүүл мэндийн мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах иргэдийг эрүүл мэндийн

хяналтад авч, хүндрэл, эрсдэлээс сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцон, зорилтот бүлэгт тогтмол хянаж наслалтыг уртасгах зорилт тавьж ажиллана.

3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад ээлтэй орчин бүрдүүлнэ.

3.4. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалд цаг алдалгүй илгээн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

3.5. Өрхийн анагаах ухаанд суурилсан тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, телемедицин, мобайл, дижитал технологийг нэвтрүүлж ажиллана.

3.6. Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед удирдах байгууллагын шийдвэрийг мөрдөж, тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлнэ.

3.7. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

Дөрөв. Төвийн эрх, үүрэг

4.1. Төв нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1. Төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, дүрэмд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг эрх эдлэх;

4.1.2. Тусламж үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн олгож буй санхүүжилтийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

4.1.3. Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн шинэ санал, санаа нэвтрүүлэх, сайн туршлагаа хуваалцах санал, хүсэлтийг дүүргийн Эрүүл мэндийн төвөөр дамжуулан шийдвэрлүүлэх;

4.1.4. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх;

4.1.5. Төвийн үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой асуудлаар санал, хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх;

4.1.6. Төрөөс болон хандив тусламжаар хуваарилагдсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд ашиглах;

4.1.7. Төвийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу нэмэгдэл хөлс, нөхөн төлбөр олгох;

4.1.8. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдал, өвчлөл, нас баралтын байдалд дүн шинжилгээ хийж, өвчлөл, нас баралтыг бууруулах, эрүүлжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах;

4.1.9. Цаг үеийн гамшиг, осол, халдварт өвчний үед нэмэлтээр ажилласан төвийн ажилчдын цалин хөлс, нэмэгдэл, эмнэлгийн хэрэгсэлд аймаг, нийслэлийн Засаг даргаас дэмжлэг хүсэх, авах.

4.2. Төв нь дараах үүргийг хүлээнэ: Үүнд:

4.2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 16, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг үүрэг хүлээх;

4.2.2. Байгууллагын үндсэн зорилго, зорилт, чиг үүргийг тодорхойлон, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.2.3. Төвийн санхүүжилт, орлого зарлагыг төвийн ажилтнуудад ил тод нээлттэй байршуулах;

4.2.4. Үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэн өрхийн эмчээ сонгох, цаг товлон үйлчлэх, тусламж, үйлчилгээ авах ээлтэй орчин бүрдүүлэх;

4.2.5. Төвийн ажилтнууд нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

4.2.6. Төв нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын цалин, урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан, шударга, ил тод зарчмыг баримтлан олгох;

4.2.7. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан анхан шатны маягтыг хөтөлж, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлэх;

4.2.8. Цахим мэдээний сангийн тогтвортой байдлыг ханган шаардлагатай тоног төхөөрөмж авах төсөвтэй байх;

4.2.9. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулах боломж, нөхцөлөөр хангах, эмч нарыг 3 жил тутам төгсөлтийн дараах сургалтад хамрагдах боломжоор хангах;

4.2.10. Ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

4.3. Төвийн даргад тавигдах шаардлага, хүлээх үүрэг:

4.3.1. Хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан хамт олны олонхын саналаар сонгогдсон байх;

4.3.2. Удирдахуйн чиглэлээр суралцсан, ил тод, нээлттэй, шударга, хамт олныг манлайлах, багаар ажиллахыг үйл ажиллагааны үндсэн зарчмаа болгож, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.3.3. Байгууллага хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг боловсруулан хамт олноороо хэлэлцүүлэн баталгаажуулсан байна. Хэтийн төлөвлөгөөний

- дагуу жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллахад хамт олноо удирдан манлайлан ажиллах;
- 4.3.4. Байгууллагын дотоод журмыг боловсруулан, хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлан, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 4.3.5. Байгууллага хамт олноо төлөөлж гэрээ байгуулах, бусад эрх зүйн баримтыг баталгаажуулах;
 - 4.3.6. Байгууллагын өмч, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, зарцуулалтыг хамт олонд танилцуулж, төсөв, хөрөнгө, хандив, тусламжийг хамт олондоо мэдээлэх;
 - 4.3.7. Эрүүл мэндийн ажилтантай “Хөдөлмөрийн тухай” хуульд заасны дагуу Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг улирал бүрээр тооцон ажиллах;
 - 4.3.8. Эмнэлгийн мэргэжилтнийг багц цагийн сургалтад хамруулах;
 - 4.3.9. Хүний нөөцийг хөгжүүлэх хэтийн болон ойрын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах;
 - 4.3.10. Төвийн ажиллах цагийн уян хатан зохицуулалтыг иргэнд ээлтэй байдлаар зохион байгуулж иргэдэд, эрүүл мэндийн газар, засаг захиргааны удирдлагад мэдээлэх;
 - 4.3.11. Хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад ажил эрхлэхгүй байх.

4.4. Төвийн даргыг дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:

- 4.4.1. Гэрээний хэрэгжилтийн хагас жилийн үнэлгээгээр “Хангалтгүй” дүгнэгдсэн;
- 4.4.2. Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;
- 4.4.3. Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;
- 4.4.4. Өөр ажилд шилжих болсон;
- 4.4.5. Ашиг сонирхлын зөрчилтэй хүнийг ажилд томилсон;
- 4.4.6. Төвийн өмч, хөрөнгийг үрэгдүүлж, шамшигдуулсан болон санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан нь хуулиар нотлогдсон;
- 4.4.7. Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдсон;
- 4.4.8. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний гүйцэтгэл “хангалтгүй” үнэлэгдсэн;
- 4.4.9. Өр үүсгэсэн;
- 4.4.10. Үйлчлэх хүрээний хүн амын сэтгэл ханамжийг харгалзан үзэх.

Төв. Төвийн гэрээ

5.1. Төв нь аймаг, нийслэлийн Засаг даргын баталснаар аймаг, нийслэл Эрүүл мэндийн газартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай чанар, үр дүнд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээг жил бүрийн 1 дүгээр сард багтаан байгуулна.

5.2. Гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан үнэлгээний баг ил тод, шударга, нээлттэй зарчмыг баримтлан тэгш эрхтэй оролцон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам”-ын дагуу жил бүр дүгнэж, үр дүнг харьяалах нутаг, дэвсгэрийн хүн амд танилцуулна.

5.3. Гэрээг дараах тохиолдолд цуцална. Үүнд:

- 5.3.1. Гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн үнэлгээгээр “Хангалтгүй” дүгнэгдсэн;
- 5.3.2. Гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан;
- 5.3.3. Эмчилгоо, үйлчилгөөний ноцтой доголдол гаргаж, иргэний эрүүл мэндэд хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
- 5.3.4. Хөрөнгө, санхүү, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон;
- 5.3.5. Төрийн болон орон нутгийн өмчийг шамшигдуулсан.

5.4. Энэхүү журмын 4.3-д заасан гэрээ цуцлах нөхцөл бүрдсэн тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээг цуцална.

5.5. Гэрээг цуцалсан тохиолдолд Эрүүл мэндийн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн багийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу дараагийн Өрхийн эрүүл мэндийн төвийн багийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар шалгаруулна.

5.6. Багийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг өмнө нь гэрээ байгуулсан Өрхийн эрүүл мэндийн төвийн баг хүлээнэ.

Зургаа. Төвийн санхүүжилт, тайлагналт

6.1. Төвийн төсөв нь улсын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

6.2. Төвийн санхүүжилтийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар улсын төсвийн эх үүсвэрээр эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцсэн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тус тус олгоно.

6.3. Нэг иргэнээр тооцсон тарифын хэмжээ болон эрүүл мэндийн даатгалын

сангаас хариуцах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг өртөг, зардал, үнийн өсөлттэй уялдуулан шинэчлэн, тогтоосон жишгийг мөрдөнө.

6.4. Төвийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд, хугацаанд нь байршуулсан байна.

6.5. Санхүүгийн зөрчил гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.6. Төв нь өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байна.

Долоо. Төрийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт

7.1. Төв нь аймаг, нийслэлийн Өмчийн харилцааны газартай "Өмч эзэмших гэрээ" байгуулан, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

7.2. Төвд ашиглагдаж буй өмч, хөрөнгийн тооллогыг жилд 1 удаа хийнэ.

7.3. Төв нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно.

7.4. Өмч, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих төр, орон нутаг, төсөл, хөтөлбөр, хандив, тусламжаар олгосон өмч хөрөнгийг бүртгэн, тоног төхөөрөмжийн ашиглалтын карт хөтөлнө.

7.5. Төв нь төрийн болон орон нутгийн өмчийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу ашиглана.

7.6. Улс, орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгийг аймаг, нийслэлийн Өмчийн харилцааны газарт бүртгүүлнэ.

7.7. Хандив, нэмэлт тусламж, үйлчилгээнээс олсон орлогоос авсан өмч хөрөнгийг нөхөрлөлийн өмчид бүртгэнэ.

7.8. Төвийн байрны их засварыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, урсгал засварыг төв хариуцан тухай бүрд хийж гүйцэтгэнэ.

7.9. Төв татан буугдсан тохиолдолд талуудын төлөөллийг оролцуулан төвийн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Өмчийн харилцааны газар, байгууллагын ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.

7.10. Харьяалах нутаг дэвсгэрт тусламж, үйлчилгээ үзүүлж буй төвийн болон шинээр төв байгуулах тохиолдолд хэрэгцээтэй байр, хөрөнгө, эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах болон санхүүжилтийн асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай хамтран шийдвэрлэнэ.